

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨХИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

Үндэслэл:

Монгол Улс хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний 5 дахь хөтөлбөрийг 1997 оноос 2020 оны хооронд Засгийн газрын тогтоолоор батлан хэрэгжүүлснээр Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн 155 дугаар конвенц”-д 1997 онд нэгдэн орж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай бие даасан хуулийг 2008 онд УИХ-ын чуулганаар батлуулж, тус хууль батлагдсанаас хойш 2011, 2012, 2015 онуудад томоохон нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан байдаг.

Сүүлийн жилүүдэд манай улсад аж үйлдвэр, уурхай, бүтээн байгуулалт эрчимжиж, үүнийг дагаад эрсдэлтэй ажлын байранд ажиллаж буй иргэн, ажилтны амь нас эрүүл мэндийг хамгаалах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээг улам сайжруулах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Өнгөрсөн 2019-2023 онд улсын хэмжээнд хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ 240 хүн амь насаа алдаж, 823 хүн хүнд гэмтэж, 686 хүн хөнгөн гэмтэж, нийт 1748 үйлдвэрлэлийн осол, хурц хордлого бүртгэгдсэн байна. Олон Улсын жишгээр жижиг, дунд үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дунд үйлдвэрлэлийн осол гарах магадлал өндөр байхын зэрэгцээ бүртгэгдээгүй осол их байдаг гэж үздэг. Манай улсад үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 3-5 хувь нь 1-9 ажиллагчтай аж ахуйн нэгж байгууллагад бүртгэгдсэн байна. Иймд аж нэгж байгууллагын дийлэнх хувийг эзэлж байгаа жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ойлголт, мэдлэгийг дээшлүүлж, тэдэн рүү чиглэсэн тусгайлсан арга хэмжээ авч ажиллах шаардлага байгааг харуулж байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний эдийн засагт үзүүлэх хохирол 2019 оны тооцоолоор 127.8 тэрбум төгрөг байна. Энэ нь манай улсын ДНБ-ий 0.4 хувь (ДНБ 2019 онд 36.9 их наяд төгрөг), нийт төсвийн зардлын 1.1 хувь, нийгмийн даатгалын сангийн зардлын 6.0 хувьтай тэнцэж байна¹.

Энэ нь зөвхөн шууд тооцогдож болох ажлын алдагдсан хугацаа, үйлдвэрлэлийн алдагдал, ажилчдын нөхөн олговор, эмчилгээний зардал зэрэгт үндэслэсэн тооцоолол юм. Түүний хажуугаар хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл

¹ ХНХЯ, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөллийн судалгааны тайлан, 2020

санаа, хохирогчийн гэр бүлд, ажил олгогчид учирч байгаа тооцоолох аргагүй асар олон хохирол, зардлууд байна.

Шинжлэх ухаан, инженерийн янз бүрийн салбар дахь судлаачид осол гэмтлээс сэргийлэх боломжтой гэдгийг олон талаас судлан шинжилсэн байдаг. Хөгжиж буй олон орны ХАБЭА-ын бодлогын тэргүүний зорилт нь урьдчилан сэргийлэхэд чиглэдэг байна. Үйлдвэрлэлийн осол, гэмтлийн бүртгэл, мэдээлэл сайн байх нь урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр өгөөжийг нэмэгдүүлэх, бодлого, төлөвлөлтийг сайжруулахад чухал ач холбогдолтой байдаг.

Хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт нийлүүлэлтийн таамаглал судалгааны тайланд ажиллах хүчний тоо өнөөгийнхөөс 2035 он гэхэд нийт ажиллах хүний эрэлт 19.1 хувиар, ҮОМШӨ-ний өндөр эрсдэлтэй уул уурхай, олборлолтын салбарт 32.5, боловсруулах үйлдвэрт 63.3, барилгын салбарт 55.9 мянган хүнээр тус тус нэмэгдэх төлөвтэй байна. Энэхүү өсөлтийг дагаад ҮОМШӨ-ний улмаас хөдөлмөрийн чадвар алдах хүний тоо, эрсдэл өсөх хандлагатай тул учирч болзошгүй эрүүл мэнд, эдийн засаг, нийгмийн сөрөг үр дагавар, дарамтаас урьдчилан сэргийлэх асуудлыг анхаарах шаардлагатайг илэрхийлж байна.

Цаашид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал, хөдөлмөрийн хяналтын тогтолцоог сайжруулах, хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн салбартай уялдуулан хөгжүүлэх, мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, статистик, судалгааг хөгжүүлэх, албан бус салбарт зориулсан зохицуулалтыг бий болгох, цахим шилжилт зэрэг тогтолцооны шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай байна.

Иймд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, олон улсын хууль тогтоомж болон үндэсний хууль тогтоомжийн нийцлийн судалгаа хийх хэрэгцээ, шаардлага үүсэж байна.

Зорилго:

Үндэсний зөвлөх нь ази, европын болон ром германы эрх зүйн тогтолцоотой улс орны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийг судалж, харьцуулалт хийж, хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах зохицуулалтын саналыг боловсруулан ажлын хэсгийн гишүүдтэй хамтран ажиллана.

Зөвлөхийн гүйцэтгэх ажил:

Зөвлөх нь дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

1. Улс орнуудын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль тогтоомжийг судлах, үндэсний хууль тогтоомжтой харьцуулсан судалгаа хийж саналын томъёолол боловсруулахад доорх агуулгыг багтаана. Үүнд:

- а. Тухайн улсын ХАБЭА-н эрх зүйн зохицуулалт, шинэчлэлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн бүтэц, тогтолцоо
- б. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг судлан бүртгэх, мэдээлэх тогтолцоо, осолд дөхсөн тохиолдлыг мэдээлэх, тавигдах шаардлага
- в. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хяналт, итгэмжлэл, баталгаажуулалт, зөвшөөрлийн тогтолцоо гэх мэт...

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад ажлын хэсэгтэй хамтран ажиллана.

Ажил гүйцэтгэх хугацаа:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад шаардагдах судалгаа болон хуулийн төслийг ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаас хойш 2 сарын дотор хийж гүйцэтгэнэ.

Зөвлөхөд тавигдах шаардлага:

1. Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар 15-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
2. Хуульч, эрх зүйч мэргэжилтэй байх;
3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, нийгмийн даатгалын чиглэлээр судалгаа хийж байсан туршлагатай байх;
4. Хариуцсан ажлаа чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, богино хугацаанд ачаалалтай ажиллах, удирдан зохион байгуулах чадвартай байх;
5. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.